

## ЭМЗҮЙ, УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААН

### Эмэгтэйн хий цус бүрэлдсэн өвчин буюу спиралийн хам шинж

*Пүрэвжав М., Мэндсайхан З.*

*Эмчилгээ судалгаа үйлдвэрлэлийн Монг-Эм эмнэлэг*

#### **Abstract**

#### **Women blood, wind stagnation composed disorder or the IUD syndrome**

*Mendsaikhan Z., Purevjav M.*

*Mong-Em Mongolian traditional medicine production and clinic*

#### **Background**

In traditional medicine women blood, qi stagnation disorder (WBQS) is caused by many reasons, such as use of spicy, hot, sour quality food and drinks for long period; hard labor; excessive or not enough sexual intercourse; not adequate post-natal care are reasons to increase of the blood-bile heat, proliferation of bad blood in uterus, leading to stagnation and growth of blood mass. Uterus blood and Qi stagnation leads into complex symptoms such as palpitations, anxiousness, depression, shoulder and neck stiffness, sleep disorder etc. There is a need to learn about current causes and treatments of this disorder and consolidate results of traditional treatments in order to give more treatment choices for patients.

#### **Objective**

Purpose of our study is to consolidate MTM treatment results of women blood, qi stagnation composed disorder.

#### **Materials and Methods**

A descriptive and retrospective study was conducted based on all medical history data of patients diagnosed and treated with this disorder during 1991-2016 in Mong-Em traditional medicine clinic.

#### **Results**

Totally 2000 cases were diagnosed with women blood, qi stagnation disorder and treated by traditional medicine methods. We have classified and treated using differentiation diagnosis of TMM theory. For example, clinical symptoms vary from palpitations, panting, sleep deprivation, chest acne, depression, mood swings, backaches, inner thigh pain, infertility, non-regular menstruations, menorrhagia, dysmenorrhea, amenorrhea, premenstrual symptoms; too thick menstruation blood, hypomenorrhea with dark, thick blood clots etc. For treatment, we used ancient prescriptions of herbal medicine, as well as acupuncture.

#### **Conclusion:**

1. IUD is one of the main reasons of Qi and blood stagnation disorder of women.
2. Based on TMM's theory and treatment principles for women qi and blood stagnation disorder, TMM appears to be give far more efficient long term results where modern medicine has limited choice of effective treatment.
3. Women qi, blood stagnation disorder is chronic disorder showing changes in laboratory examinations only in later period of time, thus reducing the possibility to be diagnosed with modern medical tests, leading to have few choices of modern medicine treatment, long term use of combined TMM drugs.
4. There is need of the whole-body approach for this disease, where modern medicine uses too narrow differentiation of diagnosis, often delaying the possibility to be treated properly in short time.

**Key words:** traditional medicine, qi stagnation disorder, IUD syndrome

Pp.58-60, References 3

**Үндэслэл**

Уламжлалт анагаах ухаанд эмэгтэйн хий цус бүрэлдсэн өвчнийг юуны түрүүнд бүхэл цогцын өвчин, хурц халуун исгэлэн чанартай идээ ундаа хэтрүүлэн удаан хугацаанд хэрэглэсэн, хатуу хүчилсэн ажил, хурьцлын үйлийг хэтрүүлсэн буюу дутуудуулсан, төрөх амаржих цагт гам алдсан зэрэг олон шалтгаанаас цус, шарын халуун аригдаж, умайд муу цус бууж, цус бүрэлдэн, улмаар умайн цусан бэтэг үүсдэг гэж үздэг бөгөөд хий хавсарч гол судалд бууснаар гол дэлсэх, санаа алдах, санаа сэтгэл тавгүйтэх, хүзүү сэрвээгээр хөшиж хөөрөх зэрэг хам шинжүүд хавсран илэрдэг өвчин болно. Уг өвчнийг үүсгэгч өнөөгийн шалтаг, шалтгаан болон эмчилгээний үр дүнд нэгтгэн, дүгнэлт хийх шаардлага байна.

**Зорилго**

Эмэгтэйн хий цус бүрэлдсэн өвчний уламжлалт анагаах ухааны эмчилгээний үр дүнг дүгнэн, нэгтгэх.

**Материал, аргачлал**

Уг судалгааг эмчилгээ, судалгаа, үйлдвэрлэлийн Монг-Эм эмнэлэгт 1991-2016 онд эмэгтэйн хий цус бүрэлдсэн өвчин оношоор хэвтэж эмчлүүлсэн үйлчлүүлэгчдийн өвчний түүхэнд дескриптив ретроспектив аргаар хийв.

**Үр дүн**

Монг-Эм эмнэлэгт тус өвчний оноштойгоор нийт 2000 хүн хэвтэж, уламжлалт аргаар эмчлүүлсэн байна. Тус өвчний шалтгаан болон эмнэл зүйн шинж, эмчилгээг нь нэгтгэлээ.

**Шалтгаан:**

1. Давтан үр хөндөлт хийлгэх;
2. Спираль тавиулаад авахуулалгүй 3 дээш хугацаагаар байлгах;
3. Жирэмслэхээс сэргийлдэг эм 6 сараас дээш хугацаагаар уух;
4. Хятад, Япон, Солонгос улсад 4-өөс дээш жил амьдарсан эмэгтэйчүүд буюу хурц халуун исгэлэн идээ ундаа тогтмол хэрэглэж зуршсан хүмүүс;
5. 40-өөс дээш насны төрөөгүй эмэгтэйчүүд, нөхөргүй олон жил амьдарсан эмэгтэйчүүд

Эмнэл зүйн шинжүүд:

1. Дотор давчдах, зүрх чичрэх, зүрх дэлсэх, нойр муудах, зүрхээр өвдөх;
2. Сэтгэл санаа үймрэх, уур уцаартай болох, амархан уйлах;
3. Ууц нуруугаар чилж өвдөх, гуяны дотор талаар өвдөх;
4. Жирэмслэхгүй болох;
5. Сарын хир тэгш бус, менструац хугацаанаас хоцорч ирэх, хэмжээ нь өөрчлөгдөх, их

хэмжээний нөжтэй ирэх, өвдөлт илрэх;

6. Менструацийн хэмжээ эрс багасаж, хэт өтгөрч, хар хүрэн болох;
7. Саваар үе үе хий гарах;
8. Сарын хир ирэхэд бие тавгүйрхэж, хөх хөндүүр, эмзэг болох;
9. Цагаанаар буух, гадна бэлэг эрхтэн загатнах;
10. Доод бие, хөл дулаацахаа болих;
11. Гэдэс дүүрэх, цанхайх, хэхрүүлж, хий гарч тавирах;
12. Хөлийн ул халуун оргих, эрээн булчин, гуя бадайрах.

**Эмчилгээ:**

1. Хий дарах эмчилгээ: Амь баригч-5, Амь баригч-11, Задь-5, Эмэгтэйн агар-8 зэрэг хийн эмүүдээс сонгож хэрэглэнэ. Өглөө эрт, орой бүрийд хийн эмийг хонины шөл болон монгол архиар даруулж уулгана.
2. Царцсан цус хайлуулах: Суман мод-6, Суман мод-7, Цээнэ-7, Гурван үр-17 эмүүдээс сонгож хэрэглэнэ. Бидний практикт Суман мод-6 танг 2 тунгаар өдөт хоёр удаа буцалгаж уулгана.
3. Сарын тэмдэг хоцрох, ирэхгүй удах, хэвлийн доод хэсгээр өвдөх зэрэг тохиолдолд Гишүүн-6 эмийг хавсран хэрэглэнэ.
4. Уруу арилгагч хийн гүйдлийг засах, гэдэс дүүрэх, шингээц тэгшгүй болох зэрэгт Амарлиулагч-6 эмийг хоолны өмнө уулгана.
5. Саваар хий гарах, хөл хөрөх зовиуртай өвчтөнүүдэд өвчтөний биеийн байдалд тохируулан Сүгмэл-7 эмийг хэрэглэж байв.
6. Климаксийн шинж илэрч, хөх хөндүүрлэх зэрэгт Өлзий-18 хавсруулан хэрэглэх нь үр дүнтэй.

**Хэлцэмж**

Лувсанчоймболын “Нандин эрдэнийн шимийн хураангуй” номын өвчний оношилгоо, эмчилгээний бүлгийн “Эмэгтэйн өвчнийг анагаах нь” хэсэгт цус бүрэлдсэн өвчний ерөнхий шинж нь: “Бэлхүүснээс доош яс шархиран өвдөх, хэвлийн доод талаар халуун оргиж базлаж өвдөх, нуруу, элэг өрцөөр хатгуулах, умайн цус алдах буюу хуйларч үгүй болно” гэсэн байна. Хий бүрэлдсэний ерөнхий шинж: “...яс шимширэх, сэтгэл амаргүй болж толгой эргэж толгойн яс янгинах, бүх бие хавдах, мах арьсны завсарт өвдөх, бие сэлхэрч, нүд бүрэлзэж солиорох буюу үхэтхийх, давсагаар өвдөх, хэвлийн доод талаар өвдөх, сарын тэмдэг булингартаж үргэлж гарна” 1 гэжээ.

Бурханч лам Чойжамц 1922 онд төвд хэлээр туурвисан “Маш гайхамшигт хуримын сан” бүтээлийн 99-р бүлэг эмэгтэйн өвчний

бүлэгт: “Шинээр цус бүрэлдэх шинж ньбие хүндэрч өвдөнө, бэлхүүснээс доош шархирах мэт эмзэглэнэ, гэдсэн дотор халуу оргиж ар ба өрцөөр хатгуулна, толгой үргэлжид өвдөх бөгөөд ундаасах нь их, бүх бие хөлөрнө. Өвчин хуучирч хий бүрэлдэх шинжид: сэтгэл амгалангүй бөгөөд солирох, мартамхай болно. Бие нь хүйтэн оргиж яс нь шархирна. Ходоод гэдэсний доогуур хөөх бөгөөд идээнд дургүй болж бөөлжинө. Сарын хир цаг бусаар бууна. Эмэгтэйн өвчин бол хэсэг бусад, халуун, хий хоёроос болж хөдөлнө, халуун өвчний үед мах нь хатаж, сэтгэл нь долгионож, нойргүй болно. Хийн шинж үзэгдвэл дээш гүйгч хий нь толгойн өвчин хөөрөлт болж урвана”<sup>2</sup> гэжээ.

Дэсрид Санжаажамц “Увдисын нэмсэн найман арга оршвой” сударт: “эмэгтэйн цус гэмтсэн билэг чанар нь бэлхүүснээс доош 9 шан хүртэл шархирч өвдөнө, умайн цус цувирах буюу тогтох бөгөөд өгөрлөх болно. Бэлхүүснээс доош яс хэмхрэх мэт болоод халуун оргино. Сарын хир таргийн шар ус мэт цувираад зүрх долгиох, шээсний сүв өвдөх бөгөөд бөөлжих мэт санагдана. Хий гэмтвээс яс шархирч, сэтгэл амар үгүй, толгой эргэж, бүх бие хавдан мах арьсны завсар өвдөн давсагаар өвдөж сарын хир үргэлж цувирна”<sup>3</sup> гэж бичжээ.

Дээрх судруудад заасан шинж нь бидний эмэгтэйн хий цус бүрэлдсэн өвчин хэмээн оношилж, эмчилсэнтэй шинж тэмдэгийн хувьд таарах бөгөөд эмчилгээнд мөн сударт дурьдагдсан эм, танг уулган, зүү, заслын аргуудыг хавсран хэрэглэсэн болно.

#### **Дүгнэлт:**

1. Жирэмсэнээс хамгаалах ерөндөгийг урт удаан хугацаагаар хэрэглэх нь УАУ-ны ном сударт заасан “Эмэгтэйн хий цус бүрэлдсэн өвчин” гэх эмгэгийг үүсгэх нэг шалтгаан болж байна.
2. УАУ-ы онол, арга зүйг үндэслэн өвчин үүсэх,

хөгжих, даамжрах эмгэг жамыг тодруулан өвчний оношилгоо эмчилгээний зарчмыг тогтоон, уламжлалт эм, тан заслын аргуудыг оновчтой хавсран хэрэглэх нь эмэгтэйн хий, цус бүрэлдсэн өвчин буюу өнөөгийн анагаах ухаанд эмчилгээний сонголт багатай байдаг эмгэгүүдэд хамгийн үр дүнтэй эмчилгээний арга гэж үзэхээр байна.

3. Эмэгтэйн хий, цус бүрэлдсэн өвчин нь архаг явцтай хууч өвчин тул урт хугацааны дараа бодит үзлэг шинжилгээгээр илэрхийц өөрчлөлт гарч байгаа нь өвчин даамжирсан хойно онош тавигдаж, эмчилгээний цөөхөн сонголттой үлдэх, илүү өвөрмөц хавсарсан эм тан заслын аргуудыг урт удаан хугацаагаар хэрэглэх нөхцлийг бүрдүүлж байна.
4. Өвчний оношилгоо, эмчилгээг хэт дифференциал болгосон орчин үеийн АУ-ны хандлагийг илүү уян хатан болгон өөрчлөж, аливаа өвчинд бүхэл цогцосын үүднээс хандах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

#### **Ном зүй**

1. Чоймбол тойн “Нандин эрдэнийн шимийн хураангуй”. УБ, 1997, х.123.
2. Чойжамц “Маш гайхамшигт хуримын сан” Орчуулсан Б.Балгансүрэн, УБ, 1991, х.88.
3. Дэсрид Санжаажамц “Увдисын нэмсэн арга оршвой” УБ, 2016, х.232.

*Танилцаж, нийтлэх санал өгсөн:  
Академич Ш.Болд*